

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн нэр	4
1.2 Төслийн зорилго	4
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
1.4 Төслийн хүчин чадал	4
1.5 Хүчин чадал, ажиллах горим	4
1.6 Ашиглалтын систем	4
1.7 Уурхайн хүрээ хязгаар	5
1.8 Уурхайн тоног төхөөрөмж	7
1.9 Төслийн дэд бүтэц	8
1.9.1 Барилга байгууламж	8
1.9.2 Усан хангамж	8
1.9.3 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам	12
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	13
2.1 Төслийн байршил	13
2.2 Төслийн газрын гадарга	14
2.3 Гидрогеологийн нөхцөл	14
2.4 Хөрсөн бүрхэвч	15
2.5 Ургамлан нөмрөг	17
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	18
3.1 Агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд	18
3.2 Газрын гадарга болон хэвлийд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд	18
3.3 Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд	18
3.4 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, эх үүсвэр	19
3.5 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ, эх үүсвэр	19
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	21
4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ	26
4.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	27
4.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ...	28
4.6 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
4.7 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31



4.9	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
4.10	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	35

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт № 2. Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд.....	5
Хүснэгт № 3. Ил уурхайн 10 дахь жилийн хүрээний үндсэн хэмжээсүүд.....	6
Хүснэгт № 4. Дайрга болон элс олборлолтын нэгтгэсэн календарь төлөвлөлт.....	7
Хүснэгт № 5. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмж.....	7
Хүснэгт №. 6 Унд ахуйн усны тооцоо.....	10
Хүснэгт №. 7. Зам талбайн усалгааны тооцоо.....	10
Хүснэгт №. 8 Биологийн нөхөн сэргээлтийн усны тооцоо.....	11
Хүснэгт №. 9 Уурхайн нийт усны тооцоо.....	11
Хүснэгт №. 10 Төслийн талбайн солбилцол.....	13
Хүснэгт №. 11 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ.....	19
Хүснэгт №. 12 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ.....	19
Хүснэгт № 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	22
Хүснэгт № 14. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	27
Хүснэгт № 15. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	28
Хүснэгт № 16. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	28
Хүснэгт № 17. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	29
Хүснэгт № 18. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	30
Хүснэгт № 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	32
Хүснэгт № 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	34
Хүснэгт № 21. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	35

Зургийн жагсаалт

Зураг 1. Барилгын чулууны ил уурхайн эцсийн хүрээ хязгаар.....	6
Зураг 2. Уурхайн ашиглалтын 5 дах жилийн зураг.....	6
Зураг 3. Худгийн байршил.....	9
Зураг 4. “Элстэйн нуруу” барилгын чулууны ордын байршлын зураг.....	13
Зураг 5. “Элстэйн нуруу” барилгын чулууны ордын байрзүйн зураг.....	14
Зураг 6. Талбайн хөрсний тархалт.....	16

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Элстэйн нуруу” барилгын чулуу, элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

1.2 Төслийн зорилго

Манай оронд сүүлийн жилүүдэд зам барилгын ажил хөгжиж үүнийг дагаад барилгын материалын үндсэн түүхий эд болох дайрганы хэрэгцээ жил ирэх тусам ихэсч байгаа төдийгүй Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хот төлөвлөлт, хотын хөгжлийг дагаад хот, тосгон хөгжиж барилга байгууламж, зам харилцаа хөгжихийн хэрээр түүнд хэрэглэдэх дайрганы түүхий эдийн хэрэгцээ улам нэмэгдэж байгааг үндэслэн “Ташгайн даваа” ХХК нь барилгын чулуу, элсний ордын хэрэгцээг хангах зорилготой үйл ажиллагаагаа явуулна.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Ташгайн даваа” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011457049
Регистрийн дугаар	5791243
Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо үйлдвэр 2 д 74-4 тоот
Утас	99114703

1.4 Төслийн хүчин чадал

Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо олборлолтын үеийн хаягдлыг 2%-аар (барилгын чулуу нийт (В+С)) 49.0 мян.м³ буюу 137.2 мян.тн, элс нийт (А+В) 1.89 мян.м³ буюу 3.42 мян.тн) ашиглалтын үед бохирдолгүй байхаар авч тооцсон бөгөөд үйлдвэрлэлийн нийт нөөц барилгын чулуу (В+С) 2400.7 мян.м³ буюу 6,722.1 мян.тн, барилгын элс (А+В) 93.1 мян.м³ буюу 167.5 мян.тн олборлохоор тооцсон байна. Жилд 60.0 мян.м³ элс олборлох хүчин чадалтай байна.

1.5 Хүчин чадал, ажиллах горим

Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо олборлолтын үеийн хаягдлыг 2%-аар (барилгын чулуу нийт (В+С)) 49.0 мян.м³ буюу 137.2 мян.тн, элс нийт (А+В) 1.89 мян.м³ буюу 3.42 мян.тн) ашиглалтын үед бохирдолгүй байхаар авч тооцсон бөгөөд үйлдвэрлэлийн нийт нөөц барилгын чулуу (В+С) 2400.7 мян.м³ буюу 6,722.1 мян.тн, барилгын элс (А+В) 93.1 мян.м³ буюу 167.5 мян.тн олборлохоор тооцсон байна. Жилд 60.0 мян.м³ элс олборлох хүчин чадалтай байна.

1.6 Ашиглалтын систем


“Элстэйн нуруу” барилгын элс, чулууны орд нь уул-техникийн ямар нэг хүндрэлгүй, ил аргаар олборлох боломжтой тул ажлыг экскаватор болон автосамосвал хосолсон, авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр үйл ажиллагаа явуулдаг.

Хүснэгт № 2. Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд


№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Ажлын доголын өндөр	м	5
2	Ажлын бус доголын өндөр	м	10
3	Аюулгүйн тавцан	м	4
4	Доголын хажуугийн өнцөг	град	60
5	Экскаваторын орлын өргөн	м	10
6	Ажлын талбайн өргөн	м	18-25
7	Автозамын налуу	%	100
8	Автозамын өргөн	м	10
9	Уурхайн хажуугийн өнцөг	град	30-35

1.7 Уурхайн хүрээ хязгаар

Элстэйн нуруу барилгын чулууны ордын бодитой (В) нөөцөд тулгуурлан боломжтой (С) нөөцийг зайлшгүй өртөх байдлаар ил уурхайн хүрээ хязгаар үүсгэлээ. Ордын хэмжээнд нийт ил уурхайгаар олборлох боломжтой 2400.7 мян.м³ барилгын чулуу өртөхөөр тооцооллоо. Үүнээс зайлшгүй өртөх боломжтой (С) зэргийн нөөц 144.1 мян.м³ байна. Мөн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилээс хамаарч ил уурхайн хүрээний гадна үлдэх (В) зэрэглэлийн нөөц 340.7 мян.м³ байна. Ордын нийт бодитой (В) зэргийн барилгын чулууг эхний 5 жилд 40.0 мян.м³, цаашдаа 60.0 мян.м³ хүчин чадлаар олборлоход орд ашиглалтын хугацаа ойролцоогоор 35 жил байна. Мөн барилгын элсний нөөцийг баттай (А) болон бодитой (В) зэргийн нөөцийг олборлох байдлаар тооцоход ил уурхайн хүрээнд нийт 95.0 мян.м³ элсний нөөц өртөж байна. Элсний уурхайг жилд 20.0 мян.м³ хүчин чадлаар олборлох ба ашиглалтын 5 дахь жилээс элсний нөөц дуусаж, цаашид зөвхөн барилгын чулууг дангаар нь олборлох юм.



Зураг 1. Барилгын чулууны ил уурхайн эцсийн хүрээ хязгаар



Зураг 2. Уурхайн ашиглалтын 5 дах жилийн зураг

Хүснэгт № 3. Ил уурхайн 10 дахь жилийн хүрээний үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Уурхайн амсрын дундаж урт	метр	340
2	Уурхайн амсрын дундаж өргөн	метр	300
3	Уурхайн дундаж гүн	метр	30

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
4	Уурхайн ерөнхий хажуугийн өнцөг	градус	30
5	Доголын хажуугийн өнцөг	градус	60
6	Ажлын бус доголын өндөр	метр	10
7	Ажлын доголын өндөр	метр	5
8	Ажлын талбайн өргөн	метр	18-27
9	Траншейн өргөн	метр	10
10	Траншейн налуу	промилль	100
11	Уурхайн талбайн хэмжээ	га	98.6

Хүснэгт № 4. Дайрга болон элс олборлолтын нэгтгэсэн календарь
төлөвлөлт

Ашиглалтын жил	Дайрга		Хөрс	Элс		Элс, Дайрга		Уулын цул
	м ³	тн	м ³	м ³	тн	м ³	тн	м ³
1	39,200	109,760	15,866	19,600	35,280	58,800	145,040	74,666
2	39,200	109,760	4,678	19,600	35,280	58,800	145,040	63,478
3	39,200	109,760	6,165	19,600	35,280	58,800	145,040	64,965
4	39,200	109,760	2,994	19,600	35,280	58,800	145,040	61,794
5	44,100	123,480		14,700	26,460	58,800	149,940	58,800
6	58,800	164,640	-	-	-	58,800	168,000	58,800
7	58,800	164,640	-	-	-	58,800	168,000	58,800
8	58,800	164,640	-	-	-	58,800	168,000	58,800
9	58,800	164,640	-	-	-	58,800	168,000	58,800
10	58,800	164,640	-	-	-	58,800	168,000	58,800
нийт	494,900	1,385,720	29,703	93,100	167,580	588,000	1,570,100	617,703

1.8 Уурхайн тоног төхөөрөмж

Уурхайд дараах үндсэн процессууд явагдана. Үүнд:

1. Өнгөн хөрсийг бульдозероор түрэх
2. Өрөмдлөг тэсэлгээ
3. Ухаж ачих, тээвэрлэх

Уурхайд ашиглах уулын ажлын үндсэн тоног төхөөрөмжүүдийг уурхайн жилийн хүчин чадал, ерөнхий механикжуулалтын бүтэц, харгалзан дараах тоног төхөөрөмжүүдийг ашиглана.

Хүснэгт № 5. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмж

д/д	Тоног төхөөрөмж	Марк	Хүчин чадал	Тоо, ш
1	Экскаватор	HYUNDAI R250LC-9	1.27 м ³	1
2	Автосамосвал	Dong Feng	16 тн	3
3	Утгуурт ачигч	XGMA951	3 м ³	1

1.9 Төслийн дэд бүтэц

1.9.1 Барилга байгууламж

Үйлдвэрийн барилга байгууламж: Төслийн хугацаанд үйлдвэрлэлийн холбогдолтой түр барилга байгууламжуудыг барьж ашиглах бөгөөд эдгээр барилгууд нь тоногдсон чингэлэг болон сэндвичэн барилга байна. Үйлдвэрлэлийн барилга байгууламжид дараах барилга байгууламжууд хамаарна.

- Шатахуун түгээгүүрийн байгууламж
- Авто засварын газар
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Хамгаалалтын хашаа, пост

Элстэйн нуруу барилгын элс, дайргын орд нь Налайх дүүргээс 20км зайд зайтай байрладаг. Цахилгаан хангамжийг Налайх түгээх төвийн Налайх-Эрдэнэ чиглэлийн 6-10 кВ-ын /ЦДАШ/ цахилгаан дамжуулах агаарын шугамаас төслийн талбай хүртэл 1.3 км зайд татна.

1.9.2 Усан хангамж

“Ташгайн даваа” ХХК нь унд ахуйн хэрэглээний ус болон нөхөн сэргээлт, зам тоосжилт дарах усны хэрэглээг гүний худаг гаргаж хангахаар шийдвэрлэсэн байна. Ил уурхай нь Туул голын сав газарт харьяалагдана. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх зүйл болон Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1-р хавсралт, Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 1-р хавсралтыг үндэслэн усны төлбөрийг төлнө.

Ус хэрэглээний тооцоо

Усны эх үүсвэр

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 05-р хорооны нутагт орших “Элстэйн нуруу” барилгын чулуу, элс хайрганы ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн ажилчдын унд ахуйн хэрэглээг гүний худгаас хангахаар байна. Цаашид “Ташгайн даваа” ХХК нь төслийн талбайн хажууд байрлах “Сэрүүн сэлбэ” ХХК-ийн эзэмшлийн худгаас зөврөөр хангахаар 2022 оны 06 сарын 09-нд гэрээ хийсэн байна.

- ✓ Худгийн байршил 107° 29' 26.37", 47° 47' 26.37"
- ✓ Усны ундарга 1.3 л/сек



Зураг 3. Худгийн байршил

Усны хэрэглэх боломжит үзүүлэлтүүд:

- Ажилчдын унд, ахуйн хэрэглээ
- Ил уурхай, зам талбайн тоосжилт
- Нөхөн сэргээлт

Ус ашиглах

Ахуйн зориулалтаар: Усыг хоол унданд, эрүүл ахуйн шаардлагын дагуу ажилчдын халуун усны газарт, хүйтний улиралд ажлын байр болон орон сууцны халаалтын зориулалтаар усыг хэрэглэнэ.

Нөхөн сэргээлтийн ажлын зориулалтаар: Эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээж зүлэгжүүлсэн талбайг болон мод, бут ургамлыг услах зориулалтаар хэрэглэнэ.

Зам усалгаа, тоос дарах зориулалтаар: Уурхайн гадна, доторх замыг тогтмол услах мөн тоног төхөөрөмж ажиллаж буй талбайг услах зэрэгт тус тус хэрэглэнэ.

Усны тооцоо

Усны зарцуулалтын тооцоог гаргахдаа, зам усалгаа, тоос дарах ажил мөн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу, (гал унтраах), ахуйн хэрэглээний усны хувьд эрүүл ахуйн шаардлагын дагуу 1 хүнд хоногт зайлшгүй шаардагдах усны хэмжээ, зэргийг тооцоолсон болно. Зам услах, тоос дарах, нөхөн сэргээлтийн усыг шүүрлийн усыг насосоор татан хэрэглэнэ.

Унд, ахуйн хэрэглээний усны тооцоо

“Элстэйн нуруу” барилгын чулуу, элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн нийт 14 хүн ажиллах ба 1 ээлжээр тасралтгүй үйл ажиллагаа явагдах ба 10 цагаар жилд 136 хоног ажиллана. Уурхайн унд ахуйн усны хэрэглээг 2015 оны 07 сарын 30-ны өдрийн Байгаль орчны сайдын тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах ус хэрэглээний норм”-ыг үндэслэн тооцсон.

Хүснэгт №. 6 Унд ахуйн усны тооцоо

Ашиглалтын жилүүд	Хоногийн усны хэрэглээ, норм м ³	Ажилчидын тоо	Жилд ажиллах хоног	Жилийн усны хэрэглээ, м ³
1	0.08	14	136	152.32
2	0.08	14	136	152.32
3	0.08	14	136	152.32
4	0.08	14	136	152.32
5	0.08	14	136	152.32
Нийт	761.6 м³			

Уурхайн орд ашиглалтын 5 жилийн хугацаанд унд ахуйн хэрэглээнд 761.6м³ усыг ашиглахаар байна.

Тоосжилтыг дарах усны тооцоо

Уурхайн тоосжилтыг бууруулах үүднээс уурхайн доторх замыг тогтмол услаж байх хэрэгтэй байдаг. Замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сар буюу дулааны улиралд явуулна. Тоосжилтыг дарах усны хэрэглээг БОНХАЖуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтанд зааснаар гудамж, зам, талбай услах усалгааны норм 1 м² талбайг услахад 2 литр ус шаардлагатай ба нэг жилд 80 өдөр услана гэж тооцов. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ.

Замын өргөн 8м, урт 1400м байна.

Хүснэгт №. 7. Зам талбайн усалгааны тооцоо

Зориулалт	Ногоон байгууламж, зам усалгааны тооцоо				
	Норм (л/м ³)	Талбай (м ²)	Хоногт услах хэмжээ м ³ /хоног	Жилд услах хоног	Нийт жилд услах хэмжээ, м ³
Зам усалгаа	0.002	11200	22	80	1760

Уурхайн ашиглалтын 5 жилийн хугацаанд 8800м³ усыг зам усалгаанд ашиглахаар байна.

Нөхөн сэргээлтийн усны тооцоо

БОНХАЖЯ–ны 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301-р тушаалын хавсралт 13-т заасан зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм-д заасны дагуу *Цэцэрлэг, зүлэг, ногоо услах норм*-ын дагуу тооцооллыг хийв. Уг норм-д 1м² талбай- 4 литр ус зарцуулна.

Төслийн үйл ажиллагааны явцад нийт 9.2 га талбай эвдрэлд өртөж байгаагаас өртөж байгаагаас 2.7 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөсөн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлын явцад усалгааг 7 хоногт 2 удаа хийх бөгөөд хүйтний улиралд болон тухайн нутгийн уур амьсгалаас шалтгаалж жилд нийт 12 удаа хийнэ.

Хүснэгт №. 8 Биологийн нөхөн сэргээлтийн усны тооцоо

№	Усны хэрэглээ /м ³ /				
	Биологийн нөхөн сэргээлт хийх талбай, 5 жилд (м ²)	1м ² -д ноогдох усны норм, м ³ /л	Усны зарцуулалт м ³ /хон	Жилд услах тоо	Нийт хэрэглэх ус, м ³ /жил
Нийт	24000	0.004	96	12	1152

Уурхайн нийт ашиглалтын 5 жилийн хугацаанд хэрэгжих ба 3 дахь жилээс нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн иймд 1 жилийн усны хэрэглээг бодож гаргалаа 1152м³ усыг нөхөн сэргээлтийн усалгаанд ашиглахаар байна.

Нийт усны тооцоо

Хүснэгт №. 9 Уурхайн нийт усны тооцоо

№	Ус ашиглалтын хэлбэр	Усны эх үүсвэр	Ашиглах усны хэмжээ		
			Хоногт /м ³ /	Жилд /м ³ /	5 жил (уурхайн ашиглалтын эхний 5 жил)
1	Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ	Гүний худгаас	1.12 м ³ /хон	152.32 м ³ /жил	761.6 м ³ /5жил
2	Зам усалгаа, тоос дарах		22 м ³ /хон	1760м ³ /жил	8800м ³ /5жил
3	Нөхөн сэргээлт хийх усалгаа		96м ³ /хон	1152м ³ /жил	(3456м ³)-төслийн 3дахь жилээс ашиглана.
4	Мод тарих усалгаа		40 м ³ /хон	480 м ³ /жил	1920 м ³ /5 жил
Нийт			159.12м³/хон	3,544.32 м³/жил	14,937.6м³/5жил

Уурхайн эхний 5 жилд нийт 14,937.6 м³ ус хэрэглэх бөгөөд унд ахуйн усны хэрэгцээ, зам талбайн тоосжилт дарах, нөхөн сэргээлтийн усалгааг “Сэрүүн сэлбэ” ХХК-ийн гүний худгаас зөврөөр хангах бөгөөд ашиглалтын 2 дах жилд өөрсдийн талбайд гүний худаг гаргахаар төлөвлөсөн байна.



1.9.3 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам

Төслийн талбайн хойд талд 1 км зайтай Налайх-Эрдэнэ чиглэлийн хатуу хучилттай авто замтай нийлдэг учир элс, хайргыг автомашинаар тээвэрлэх бүрэн боломжтой байна. Уурхайгаас хатуу хучилттай авто зам хүртэлх 1 км замыг Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын дагуу хатуу хучилттай болгохыг зөвлөж байна.


БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Төслийн байршил

“Элстэйн нуруу” барилгын чулуу, элсний орд нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт хамаарна. Улаанбаатар хотоос зүүн зүгт 60 км, Налайх дүүргээс зүүн тийш 20 км-т, Төв аймгийн Эрдэнэ сумын төвөөс баруун зүгт 22 км тус тус зайтай оршино.

Хүснэгт №. 10 Төслийн талбайн солбилцол


№	Уртраг	Өргөрөг	Талбай, га
1	107° 30' 1.45"	47° 47' 6.77"	34
2	107° 30' 1.45"	47° 47' 12.76"	
3	107° 30' 58.44"	47° 47' 12.76"	
4	107° 30' 58.44"	47° 47' 2.77"	
5	107° 30' 12.44"	47° 47' 2.77"	
6	107° 30' 12.44"	47° 47' 6.77"	



Зураг 4. “Элстэйн нуруу” барилгын чулууны ордын байршлын зураг

2.2 Төслийн газрын гадарга

Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулсын баруун урд хэсэгт уртаараа 20км, өргөнөөрөө 10 км хүртэл үргэлжлэх ба Налайхын хотгорт хамаарагдана. Уул зүйн хэлбэршлийн хувьд далайн түвшнээс дээш 1400-1550м өргөгдсөн хотгор гүдгэр хэв шинжтэй, намхан бэсрэг уулсын толгодорхог гадаргуутай юм. Хайгуулын талбайн хувьд зүүнээс баруун тийш дунд зэрэг налуу уулын хажуу бэл болох бөгөөд талбайн баруун хэсгээр тэгшивтэр гадаргуутай, хамгийн өндөр цэг нь 1477.0 тоот өндөрлөг бол нам цэг нь 1412.0 тоот цэг болно.



Зураг 5. “Элстэйн нуруу” барилгын чулууны ордын байрзүйн зураг

2.3 Гидрогеологийн нөхцөл

Ордын талбай нь Төв Азийн гадагш урсгалгүй савд хамаарах, Монгол орны гидрогеологийн мужлалаар Төвийн системийн грунтын ус зонхилсон Туул голын ай савд багтдаг.

Дүүргийн гидрогеологийн нөхцөлийг тодорхойлохдоо өмнөх судлаачид стратиграфийн нэгж биш, харин газрын доорх усны байгалийн баялаг үүсэх нөхцөл, гидрогеологийн структур-формацын гидродинамикийн нөхцөлийг тодорхойлдог

шүүрэлтийн орчин гол үндэс болгон ус агуулагч чулуулгийн гарал үүсэл, шинж чанараар нь уст давхарга, усажсан бүсийг бүлэглэн уст бүрдлүүдийг ангилсан. Үүнд:

- Дөрөвдөгчийн сэвсгэр хурдастай холбоотой уст бүрдэл
- Палеозойн тунамал-туфоген чулуулагтай холбоотой уст бүрдэл
- Гүний чулуулагтай холбоотой уст бүрдэл

Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дахь уст бүрдэл: Ус агуулагч чулуулаг нь гарал үүслийн төрлөөрөө аллюви, аллюви-пролюви, делюви-пролюви гэж ангилагдахаас гадна байрлаж буй байдлаараа өндөр дэнж, жалга, татам, голдирол, хуурай сайрын хэмээн ангилж болно. Дөрөвдөгчийн хурдсан дахь харьцангуй өндөр усжилттай давхарга нь дүүргийн хэмжээнд нэлээд өргөн тархалттай бөгөөд голоцены делюви-пролюви болон аллювийн гаралтай шаварлаг материал агуулсан элс, элсэнцэр, сайн мөлгөржсөн хайрга хайрганцар, дайргуудаас бүрдэнэ. Энэ хэсгүүдээр байнгын гадаргуугийн устай гол, горхиуд байрлах ба жилд дунджаар 150-180 хоног мөсөн бүрхүүлтэй байж, мөсний зузаан 50-70см байдаг. Ус агуулсан үеийн зузаан дунджаар 2-3м заримдаа 5-8м хүрнэ. Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дахь уст бүрдлийн химийн найрлагын хувьд гидрокарбонат анион, кальци, магни-натрийн катион зонхилсон байх ба ундарга нь дунджаар 0,3м/сек, ус нь цэнгэг, гидрокарбонат найрлагатай, 290мг/л эрдэсжилттэй байдаг.


Палеозойн тунамал-туфооген чулуулагтай холбоотой уст бүрдэл: Чулуулгууд нь тектоник хөдөлгөөн, магмын үйл ажиллагааны үр дүнд ан цав, хагарал эвдрэлд хүчтэй орсон учир гүний болон хур тундасны усаар дүүрч гадагш булаг шандын хэлбэрээр нэвчин шүүрдэг. Гол бүрдүүлэгч чулуулаг нь элсэн чулуу, занар, алевролит, филлит байдаг. Хожуу палеозойн тунамал-туфоген чулуулагтай холбоотой уст бүрдлийн химийн найрлагын хувьд гидрокарбонат сульфатын анион, натри-кальци, магнийн катион зонхилсон байх ба ундарга нь 0.4м/сек, ус нь цэнгэг, гидрокарбонат найрлагатай, 122мг/л эрдэсжилттэй байна. Энэхүү уст бүрдлийн эрдэсжилт багатай (122мг/л) усыг хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамжийн зориулалтаар ашиглах бүрэн боломжтой юм.

Гүний чулуулагтай холбоотой уст бүрдэл: Ус агуулагч гүний чулуулгийн бүрдэл нь дүүргийн баруун хойд болон зүүн урд хэсгээр тархдаг. Гүний чулуулаг дахь ан цавын ус нь гадаргууд булаг болон гарч ирэхээс гадна гадаргын хэсэгт даган урсаж сэвсгэр хурдсанд шингэх буюу гол горхийг тэжээдэг. Чулуулгийн ан цавшилтын гүн нь 10-15м хүрдэг бөгөөд гол чулуулаг нь лейкогранит, гранит, гранодиорит, байдаг. Ус агуулагч ан цавын чиглэл нь харилцан адилгүй байна. Гүний чулуулагтай холбоотой уст бүрдлийн химийн найрлагын хувьд гидрокарбонат сульфатын анион, натри-кальци, магнийн катион зонхилсон байх ба дунджаар ундарга нь 0.3м/сек, ус нь цэнгэг, гидрокарбонат найрлагатай, 120мг/л эрдэсжилттэй байна.

2.4 Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Ташгайн даваа” ХХК-ийн 20/М031 тоот түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

барилгын чулуу, элсний ордын талбай нь нийт 34 га талбайн хэмжээтэй бөгөөд хээрийн ба хуурай хээрийн хүрэн хөрс тархана.



Зураг 6. Талбайн хөрсний тархалт

Энэ хэвшинжийн хөрс Монгол орны тал хээр, уулсын хоорондох хөндий хотгорт өргөргийн ба хотгорын бүс, дэд бүсүүд үүсгэж дорнод хэсэгт 600-700 м-ээс өрнөд хэсэгт 2300-2400 м хүртэл үнэмлэхүй өндөрт хамгийн түгээмэл тархсан байна. Ургамал бүрхэвчид нь үетэнт, агь-үетэнт, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ба заримдаа цөлөрхөг хээрийн ургамалшил зонхилж, харгана байнга тааралдана. Газрын дээрх ургамлын массын (фитомассын) хэмжээ 6-27 ц/га, газрын доорхи нь 170-400 ц/га хүрдэг.

Хүрэншороон хөрсний профиль дараах үе давхаргуудаас тогтоно: А-В-ВСа-ВССа-ССа.

Ялзмаг хуримтлалын давхарга (А) нь бараан хүрэн, хүрэн, цайвар хүрэн өнгөтэй, өнгөнийх нь байдал ялзмагийн хуримтлалтай шууд холбоотой, бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй, жижиг сайр чулуу бараг байнга агуулсан байдаг, доод хил нь тод ялгарч зааглагддаг, зузаан нь янз бүр, 10 см-ээс 30-35 см хүртэл хэлбэлзэнэ.

Шилжилтийн ялзмагт (В) давхарга тод бор, цайвар бор өнгөтэй, бусад давхаргуудаас арай хурц туяатай, нягтавтгар, хил зааг нь тод, зузаан нь 10-25 см заримдаа эртний цэвдгийн ан цаваар доошоо 40-80 см хүртэл хошуурч орсон байна. Энэ давхарга хархүрэн, хүрэн

хөрсөнд байхаас цайвар хүрэн хөрсөнд А давхаргын доор шууд карбонатын (BCa) давхарга оршино.

Карбонатын хуримтлалын (BCa, BCCa) давхаргууд нь нэлээд нягт, шороондоо нэвчиж шингэсэн карбонатын цайвар өнгөр толбуудтай, заримдаа бүр гурил шиг нунтаг цагаан толбо тогтсон байна. Сайр чулуунуудын доод талд 1-5 мм нимгэн карбонатын давсны цагаан хальслаг хучаас тогтсон, тэр нь карбонатын шинэхэн өнгөрөөр бүрхэгдсэн нь гараар барихад шохой шиг наалдана. Энэ нь хөрсөн дотор карбонатын давс байнга доошоо зөөгдөж хөдөлгөөнтэй байдгийг гэрчилж буй хэрэг.

Хөрс үүсгэгч эх чулуулаг (ССа) нь пролюви, делюви, эртний аллювийн болон салхин гаралтай сайргархаг хөнгөн шавранцар, сайргархаг элсэнцэр болон элсэн, заримдаа алтан химэрлэг (лёсс) маягийн хурдасаас тогтох бөгөөд карбонатгүй байх нь ховор. Хүрэн шороон хөрсөнд хялбар уусах давс болон гөлтгөнө ерөөс байхгүй, түүнчлэн мараалаг шинжтэй байх нь цөөн, хааяа тааралдахдаа үлдмэл мараалаг байдаг нь сонин. Хээр тал нутгаар олон жил хөрсний судалгаа хийж энэ тэрийг ажиж явахад жинхэнэ хээрийн мараа, орчин үеийн үүсэлтэй мараалаг хөрс бараг тааралдаагүй гэхэд болно.

Манай орны хүрэншороон хөрсөнд эртний үйл явцын ул мөр болох морфологи шинжүүд тод хадаглагдан үлдэж орчин цагийн үйл явцтай сүлжилдэн орших нь нэн түгээмэл. Тухайлбал, үлдмэл нугархаг шинж, эртний цэвдгийн гаралтай ан цав, үлдмэл карбонатын хуримтлал, үлдмэл мараалаг шинж зэргийг дурьдахад хангалттай. Эдгээр шинжүүд нь орчин үеийн хөрсний төрх байдалд зохих хэмжээгээр нөлөөлөх нь гарцаагүй учраас түүнээс үүдэлтэй ялгааг үндэслэн хөрсний зарим төрлүүдийг ялгахад хүрсэн юм.

2.5 Ургамлан нөмрөг

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Ташгайн даваа” ХХК-ийн 20/М031 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй барилгын чулуу, элсний ордын талбай нь ургамлын ангилал бэлчээрийн төлөв байдал, шинж чанараас хамаараад хээрийн ба хуурай хээрийн тойрогт хамаарагдаж байна. Монголын хээр нь нутгийн дорнод хэсэгт байх ба Хянганы уулсаас баруун тийш Хангайн уулсын өмнөд хэсгээр байрладаг, нам уул, хотгор гүдгэр, ухаа гүвээт тэгшивтэр газраар оршино. Хээрийн бүс нутаг дэвсгэрийн 26.1%-ийг эзлэнэ. Монголын хээр хуурайсаг олон наст ургамлуудаас бүрддэгээрээ онцлог бөгөөд энд дэгнүүлт үетэн, үндэслэг ишт үетэн, алаг өвсний хамт голлох үүргийг гүйцэтгэдэг ба зонхилгч үетэн нь хялгана, хазаар өвс, түнгэ, туужууны биелэг, дааган сүүл зэрэг байдаг. Мөн хуурайсаг сөөг ургамал болох харгана нилээд ургадаг.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

“Элстэй нуруу” барилгын чулуу, элсний ордыг ашиглах явцад агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд нь:

- Хөрс хуулах, элс хайрга олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ.
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- Уурхайн машин техникүүдийн түлшний шаталтаас ялгарах утаа, тортог, хорт хийнүүд
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол
- Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

3.2 Газрын гадарга болон хэвлийд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

Одоогийн байдлаар газрын гадарга болон хэвлийд их хэмжээний эвдрэл болон нөлөөлөл байхгүй. Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн малталт, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүсэх юм.

Уурхайн барилга, угсралтын үед уурхайн төлөвлөгдсөн талбай нь барилгын материалыг тээвэрлэх замаар эвдэгдэх талбай харьцангуй бага байна. Учир нь одоо ашиглагдаж байгаа орон нутгийн болон улсын чанартай авто замуудыг ашиглах бүрэн боломжтой байна.

Уурхай ашиглалтын явцад ил уурхайн олборлолтын талбай, чулуулгын гадаад овоолго, үйлдвэрлэлийн талбай, уурхайн доторх зам харилцаа барилга байгууламж зэрэгт 9.2 га газар өртөхөөр байна. Мөн төсөл хэрэгжих бүсийн газрийн гадаргын температурын зургийг үзэхэд гадаргыг ургамлан бүрхэвч бага тул гадаргийн температур харьцангуй өндөр байна.

3.3 Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй. Үүнд:

- ✚ Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох

- ✚ Уулын малгалтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- ✚ Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- ✚ Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- ✚ Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах
- ✚ Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- ✚ Уурхайн байгууламж, хоосон овоолго, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магадлалтай.

3.4 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, эх үүсвэр

Хүснэгт №. 11 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ				Нийт
		Бага	Дунд	Их	Маш их	
1	Агуулахын үйл ажиллагаа			1		1
2	Дотоод болон гадаад тээвэр		1		1	2
3	Дэд бүтцийн барилга угсралт	2		2		4
4	Засвар үйлчилгээ			1		1
5	Өрөмдлөг тэсэлгээ		1	1		2
6	Ухаж ачих		1	1		2
7	Хаягдлын аж ахуй		1			1
8	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа			1		1
9	Шатахуун хадгалах, түгээх			2		2
10	Шимт хөрс болон хаягдал чулуулгийн овоолго байгуулах		1	1		2
Нийт /тоогоор/		2	5	10	1	18
Нийт /хувиар /		11%	28%	56%	6%	100%

3.5 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ, эх үүсвэр

Хүснэгт №. 12 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Төслийн үйл ажиллагаа	Нөлөөллийн үнэлгээ				Нийт
		БАГА	ДУНД	ИХ	МАШ ИХ	
1	Агуулахын үйл ажиллагаа		1			1
2	Бутлан ангилах цех		2			2
3	Дотоод болон гадаад тээвэр	1	1			2
4	Дэд бүтцийн барилга угсралт	2	2			4



5	Завсар үйлчилгээ		1			1
6	Өрөмдлөг тэсэлгээ	1				1
7	Уурхайн малталт хийх	2	1	1		4
8	Ухаж ачих	1				1
9	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа		1			1
10	Шатахуун хадгалах, түгээх		1			1
11	Шимт хөрс болон хаягдал чулуулгийн овоолго байгуулах	1	3			4
Нийт тоогоор		8	13	1	0	22
Нийт хувиар		36%	59%	5%	0%	100%

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Улаанбаатар хот, Налайх дүүргийн 5-р хорооны нутагт хэрэгжүүлж буй “Элстэйн нуруу” барилгын чулуу, элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.



4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт стандарт
Агаар орчин							
Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил -Уурхайн үйл ажиллагаанд	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх /Салхи, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг багасгахдаа 2л/м ² нормоор өдөрт 2-оос доошгүй удаа усална./	Технологийн дотоод, гадаад замууд	-	2,000.0	-	Тоосжилт ихтэй үед усалж байх	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000
	Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах амны маск, хамгаалах хувцас хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	ш	500.0	-	2026 он	MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
	Хог хаягдлын цэг болон бие засах газар түүний ойр орчимд тогтмол ариутгал хийж байх	Хог хаягдлын цэг	-	200.0	-	2026 он	
	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Төслийн талбай	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан	-	2026 он	



ашиглаж буй тээврийн хөдөлгөөн	Хүнд механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх	Уурхайн техник хэрэгслүүд	ш	ҮАЗ-д тусгасан	-	2026 он	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг							
Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахгүй байх, хориглосон таних тэмдгүүдийг байршуулах	Уурхайн талбайд	-	300.0	-	2026 он	Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS
	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	ШТМ	-	ҮАЗ-д тусгасан	-	2026 он	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”
	Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг цементлэх, засч сайжруулж байх	Уурхайн талбайд	-	500.0	-	2026 он	MNS5915:2008 MNS5916:2008 MNS5917:2008 MNS5914:2008
	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Уурхайн талбайд	-	Хог хаягдлын МТ-д тусгасан	-	2026 он	
Усан орчин							
	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагатай байгуулах	Төслийн явцад	-	ҮАЗ-д тусгасан	-	2026 он	Усны тухай хууль,



Усны нөөц багасах, түвшин буурах	Унд ахуй хангаж буй усанд хяналт шинжилгээг явуулах	Уурхайн усан хангамж хангаж буй гүний худаг	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан		2026 он	“Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
Машин механизмийн шатахуун, түлш, тос асгарах /ШТМ/, улмаар хөрсөөр нэвчин гүний усны чанар стандарт өөрчлөгдөх	Уурхайн ажил явагдах нийт хугацаанд ШТМ болон хорт хаягдал асгарахаас сэргийлэх тэдгээрийг ил задгай хаяхгүй байх ШТМ хөрсөнд шууд асгарсан тохиолдолд түүнийг саармагжуулах, зайлуулах арга хэмжээг авч ажиллах	Төслийн явцад	-	ҮАЗ-д тусгасан	-	2026 он	
Амьтны аймаг							
Хог хаягдлыг амьтанд хоргүйгээр шийдвэрлэх	Хог хаягдлыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Хог хаягдлын хүрээнд	-	Хог хаягдлын МТ-д тусгасан	-	2026 он	Хог хаягдлын тухай хууль 2017 он Амьтны тухай хууль 2012 он
	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд хальгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Хог хаягдлын хүрээнд	-	Хог хаягдлын МТ-д тусгасан	-	2026 он	



Хөрсөнд үүрлэдэг жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх, ажиллагсдад байгаль орчныг хамгаалах сургалт зохион байгуулах	Нийт ажиллагсад	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан	-	2026 он	
мян.төг			3,500.0				



4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ

Ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

2026 онд уул техникийн нөхцлөөр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй бөгөөд ил уурхай болон овоолго хаагдах болоогүй тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй бөгөөд УАТ-д мөн биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил тусгагдаагүй тул 2026 оны нөхөн сэргээлтийн ажлыг дүйцүүлэн хамгаалах ажлаар хийж гүйцэтгэхээр заагдсан.



4.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 14. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн кемп орчимд мод тарих	Мод тарих, тарьсан модны усалгаа, арчилгааг хийх	100	-	5,000.0	2026 онд	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008 MNS5916:2008 MNS5917:2008
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд Нийслэлийн БОГазраас санал авах	-	-	-	9,000.0	2026 онд	
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нийт дүн						14,000.0	



4.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 15. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал сая төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт стандарт
Талбай дээр нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох айл байхгүй тул байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй							

4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 16. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал сая төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт стандарт
Төслийн талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн V хороонд байршиж байна. Тус талбайд ямар нэгэн археологи палентологийн олдвор байхгүй ба үйл ажиллагааны явцад олдвор илэрсэн тохиолдолд Соёлын өвийн тухай хуулийн дагуу холбогдох газарт мэдэгдэн хамгаалалтанд авна.							



4.6 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 17. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	500,0	2026 онд
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	1,000.0	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	-	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	1,000.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		2,500.0	



4.7 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 18. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Налайх дүүргийн ТҮГ-тай хог хаягдлын гэрээ байгуулах	Уурхайн хотхон	ҮАЗ-д тусгасан	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	600,0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	ШТС, Ажилчдын байр	1,000.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах	Нийт ажиллагсдад	500.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Уурхайн ашиглалтын талбайд	1,000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	ҮАЗ-д тусгасан	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд	
			3,100.0		



4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ташгайн даваа” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Ташгайн даваа” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Ташгайн даваа” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.



Хүснэгт № 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол						
1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа	300,0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никелийг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис,
2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа	350,0	
3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа	300,0	



						элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худаг	Унд ахуйн ус хангаж буй гүний худаг	Жилд 1 удаа	350,0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ		Жилд 1 удаа	350,0	MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					1,650.0 мян.төг	



4.9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаал	Тайлбар
			Сар 5	Сар 9	Сар 12		
1	2026 оны биелэлтийн тайланг тайлагнана.	-	11 сарын 1-ээс өмнө			Гүйцэтгэх захирал	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Менежер	
3	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогмолжуулж илэрсэн зөрчилийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	2,000.0	+	+	+	Менежер	
4	Ажилчдыг шаардлагатай ажлын хувцасаар хангах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Менежер	
5	Нийт ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Дотоод төлөвлөлтөөр	-	-	+	Менежер	
6	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа багаж хэрэгсэл хайрцагтай болох	1,000.0	+	+	+	Менежер	
7	Хог хаягдлын гэрээг Налайх дүүргийн ОНОӨТГ-тай байгуулах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Захирал	
Нийт			3,000.0				



4.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт № 21. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал төг	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан	Тайлбар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Улаанбаатар хотын Налайх дүүргийн засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж бичвэр хэлбэрээр налайх дүүргийн засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ	2026 оны 11 сарын 1-ний дотор	-	Байгаль орчны мэргэжилтэн	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж хянуулах
2	БОМТ-ний биелэлтийн үр дүнг нийслэлийн БОУАӨЯ болон Нийслэлийн байгаль орчны газраар хянуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж бичвэр хэлбэрээр нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	БОМТ		-		



2026 оны БОМТ-д сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 3500000, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд 14000000, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 2500000, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 3100000, удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 3000000, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 1650000 төгрөг, нийт 27750000 төгрөг зарцуулахаар тусгасан.

Хүснэгт № 22. БОМТ нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал (төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,500,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	14,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,500,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,100,000
8	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	3,000,000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,650,000
2026 оны БОМТ-ний нийт зардал		27,750,000